

2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж, Хорин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал үйл ажиллагааны зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “... Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлд заасны дагуу сонгуулийн холимог тогтолцоогоор сонгож байгуулсан 126 гишүүний бүрэлдэхүүнтэй Улсын Их Хурлын бүрэн эрх 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр анхдугаар чуулганаа хийж тангараг өргөснөөр хэрэгжиж эхэлсэн билээ. Ес дэх парламентын бүрэн эрх хэрэгжиж эхэлснээс хойш 4 дэх ээлжит чуулган хуралдаж байгаа бөгөөд ээлжит бус 1 чуулганыг хуралдуулсан байна. Энэ хугацаанд:

- ✓ 2024 оны намрын ээлжит чуулганаар анхдагч хууль 8, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 29, олон улсын гэрээ соёрхон батлах тухай хууль 7, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 8, Улсын Их Хурлын тогтоол 57;
- ✓ 2025 оны хаврын ээлжит чуулганаар анхдагч хууль 1, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 61, олон улсын гэрээ соёрхон батлах тухай хууль 2, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 1, Улсын Их Хурлын тогтоол 60;
- ✓ 2025 оны намрын ээлжит чуулганаар анхдагч хууль 5, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 5, олон улсын гэрээ соёрхон батлах тухай хууль 4, Улсын Их Хурлын тогтоол 36;
- ✓ 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд одоогийн байдлаар анхдагч хууль 1, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 9, олон улсын гэрээ соёрхон батлах тухай хууль 1, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 1, Улсын Их Хурлын 16 тогтоол батлаад байна.

Үүнийг нэгтгэн үзвэл, ес дэх парламент бүрэн эрхийнхээ 2 жилд нийт 18 анхдагч хууль, 126 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 14 олон улсын гэрээ соёрхон баталж, 11 хуулийг хүчингүй болсонд тооцсоноор нийт 163 хууль, харин 200 тогтоол баталсан тоон үзүүлэлттэй байна. Энэхүү тоон үзүүлэлтийг үе үеийн Улсын Их Хурлын бүтээмжийн тоон үзүүлэлттэй харьцуулан үзвэл 1 дэх бүрэн эрхийн хугацаанд 367; 2 дахь бүрэн эрхийн хугацаанд 461; 3 дахь бүрэн эрхийн хугацаанд 731; 4 дэх бүрэн эрхийн хугацаанд 530; 5 дахь бүрэн эрхийн хугацаанд 722; 6 дахь бүрэн эрхийн хугацаанд 1240; 7 дахь бүрэн эрхийн хугацаанд 1119; 8 дахь бүрэн

эрхийн хугацаанд 1838 хууль (*бие даасан, нэмэлт, өөрчлөлт, олон улсын гэрээ соёрхон батлах, хууль хүчингүй болгох, анхдагч зэрэг зөвхөн баталсан хуулийн тоо*) баталсантай харьцуулахад, ес дэх парламент бүрэн эрхийнхээ 2 жилийн хугацаанд баталсан хуулийн тоогоор 2020-2024 онд бүрэн эрхээ хэрэгжүүлсэн парламентын 4 жилийн хугацаанд хэлэлцэн баталсан хуулийн 8.9 хувийг эзэлж байна.

Энэ нь бид хууль тогтоох, хянан шалгах, төлөөлөх бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгаадаа дүгнэлт хийн, бүрэн эрхийн үлдсэн хугацаандаа улс орны нэн тулгамдсан асуудал, ард иргэдийн амьдралд шаардагдаж буй бодлогын асуудлуудад анхаарч ажиллах бодит хэрэгцээ шаардлага үүссэнийг тодорхой харуулж байна.

Нөгөө талаас Улсын Их Хурлын бүтээмжийг нэмэгдүүлэх, салбарын бодлого удааширч байгаа байдлыг засах, салбарын бодлогын асуудлуудыг эрчимжүүлж, шаардлагатай эрх зүйн орчны шинэчлэлийг хийх төрийн эрх барих дээд байгууллагын үндсэн үйл ажиллагаа удааширсан байдлыг засах практик хэрэгцээ шаардлага үүсжээ.

Тухайлбал, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг шинэчлэн найруулж батлахдаа 11 Байнгын хороотой ажиллахаар тусгасан байсныг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж Байнгын хороодын тоог 8 болгож, зарим бодлогын байнгын хороодыг нэгтгэн, харин Байнгын хорооны харьяанд 15 дэд хороо ажиллахаар тусган баталсан юм.

Улмаар 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд холбогдох Байнгын хороодын харьяанд ажиллаж буй дэд хороодын хуралдсан байдлыг дүгнэж үзвэл Тусгай хяналтын дэд хороо, Ёс зүйн дэд хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, Хүний эрхийн дэд хороо, Боловсрол, шинжлэх ухааны дэд хороод 1-2 удаа хуралдсан бол бусад дэд хороод хуралдаагүй байна. Зарим дэд хороодын үйл ажиллагаанд хамаарах асуудлын хүрээ, чиг үүргийн зааг ялгаа тодорхойгүй байж, харьяалах Байнгын хорооны эрхлэх асуудалтай давхардах нөхцөл байдал үүсэж байгаа тул зохион байгуулалтын хувьд оновчгүй байна.

Харин 2026 оны хаврын ээлжит чуулган эхэлснээс хойш Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо 4 удаа, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо 1 удаа, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хороо 3 удаа, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо 2 удаа, Хүний эрхийн дэд хороо 1 удаа тус тус хуралдсан бол 10 дэд хороо хуралдаагүй.

Тиймээс Улсын Их Хурлын зохион байгуулалтыг оновчлох, үйл ажиллагааг боловсронгуй болгон сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, бодлогын шийдвэрийг илүү мэргэшсэн байдлаар хэлэлцэн уялдаа холбоотой, нэгдмэл байдлаар гаргах, мэргэшсэн Байнгын хороодод түшиглэсэн парламентыг бэхжүүлэх зорилтын хүрээнд эрхлэх асуудлын уялдаа холбоо, чиг үүргийн заагийг тодорхой болгох зорилгоор зарим дэд хороодын тоог цөөрүүлж, харин шаардлага, ач холбогдол нь хэвээр байгаа асуудлаар Байнгын хороодыг нэмж байгуулах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Эрдэм боловсролтой Монгол хүн”, “Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол”,

“Мэдлэг, чадвартай мэргэжилтэн”, “Багшлах хүний нөөц”, “Цахимжсан боловсрол” зорилтын хэрэгжилтийг хангах, бүх шатны боловсролын тогтолцоо, агуулгын нэгдмэл бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд Засгийн газрын 2025 оны 158 дугаар тогтоолоор 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласан. Боловсролыг дэмжих жилийн хүрээнд багш бэлтгэх тогтолцоо, хичээлийн хөтөлбөрийн шинэчлэл, багшийн нийгмийн баталгаа, цалин хангамж, сургуулийн менежментийн шинэчлэл, шинэ сургууль, цэцэрлэг барих хөрөнгө оруулалт, бага сургуулийн цогцолборуудыг нэмэгдүүлэх, ахлах сургуулиудыг төрөлжүүлэн хөгжүүлэх, их сургуулиудын шинэчлэл, хөрөнгө оруулалт зэрэг асуудлууд тодорхой шийдэлд хүрэх боломж бүрдэх, боловсролын салбарт дэмжлэг үзүүлэх, салбар дундын хамтын ажиллагаа, уялдааг хангах томоохон үйл ажиллагааг амжиж хэрэгжүүлэхийг зорьсон, Улсын Их Хурал боловсролын салбарт үүсээд буй өнөөгийн нөхцөл байдал, хүндрэлийг богино хугацаанд даван туулж, дээрх асуудлыг шийдвэрлэхийг дэмжиж ажиллах шаардлагатай тул Боловсролын байнгын хороог Эрүүл мэнд, нийгмийн бодлогоос тусад нь дагнан байгуулах нь зүйтэй гэж үзэж байна;

- 2026 оны 08 дугаар сарын 17-оос 08 дугаар сарын 28-ны хооронд Монгол Улсад НҮБ-ын “Цөлжилттэй тэмцэх конвенц”-ын талуудын 17 дугаар Бага Хурлыг зохион байгуулахаар тов гаргаж, бэлтгэл ажил ханган ажиллаж байна. Уг Бага Хуралд Цөлжилттэй тэмцэх конвенцод нэгдсэн 197 улс орох бөгөөд энэ нь Монгол Улсын хувьд бусад орны өмнө хүлээсэн томоохон үүрэг болоод байна. Монгол Улсын хувьд нийт нутаг дэвсгэрийн 77 хувь нь доройтсон, цөлжилтөд хамгийн их өртсөн орнуудын нэг болсон тус хурлыг тус хурлыг эх орондоо зохион байгуулснаар газрыг нөхөн сэргээх, тогтвортой газрын менежментийг хэрэгжүүлэх, уян хатан байдлыг бий болгох шийдлүүдийг боловсруулах тул төр засаг бүхий л түвшинд уг хуралд бэлтгэн, 2026 он гарсаар үйл ажиллагаагаа улам бүр эрчимжүүлж байна. Монгол Улсын өмнө тулгамдаж буй эдгээр асуудлаар шаардлагатай бодлого тодорхойлох, түүнчлэн олон улсын өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх бодитой шаардлагын улмаас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн байнгын хороог дагнан байгуулах нь зүйтэй гэж үзлээ.
- Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд боловсруулах салбарын боловсруулалтын түвшнийг дээшлүүлж, бүтээмж, төрөлжилтийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэх орчныг сайжруулж, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, Монгол Улсын хөгжилд оруулах шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмрийг дээшлүүлж, төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж, судалгааны үр дүн, оюуны өмч, шинэ технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломжийг нээх чиглэлээр ирэх 5 жилд үндэсний хэмжээний төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсний хүрээнд Цахим хөгжлийн байнгын хороог дагнан байгуулах нь зүйтэй гэж үзлээ.
- Хүнсний аюулгүй байдал, дотоодын үйлдвэрлэл, мал аж ахуй, газар тариалангийн хөгжил нь Монгол Улсын эдийн засаг болон үндэсний аюулгүй байдлын бодлоготой шууд холбогдох стратегийн ач холбогдолтой салбар бөгөөд энэ хүрээнд парламентын түвшинд тусгайлан анхаарч, бодлого хэлэлцэх шаардлага улам бүр нэмэгдэж байна. Түүнчлэн байгалийн баялагт

тулгуурласан эдийн засгийн нэг туйлт хэлбэрийг өөрчилж, Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх гол салбар бол хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар тул Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн байнгын хороог дагнан байгуулах нь зүйтэй гэж үзэв.

- Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” хэмээн заасныг амьдруулах зорилгоор 2022 онд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлтээр оруулж, улмаар 2023 оны 10 сард цахим систем нь ашиглалтад орсон байна. Энэ хугацаанд нийт 8 өргөдөл 100,000 иргэний санал авсан боловч зөвхөн нэг л асуудлаар хуулийн төсөл боловсруулж Улсын Их Хурлаар хэлэлцсэн байдаг. Нийтийн өргөдөл (public petition) бол бодит амьдралаас урган гарч байгаа иргэдийн хэрэгцээ, шаардлага бөгөөд Улсын Их Хурлын гишүүд ард түмний элч, Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага. Иймд ард иргэдийнхээ бодит амьдралд тулгамдаад буй асуудалд парламент соргог хандаж, ард иргэдийнхээ амьдралын хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх бодит шаардлага тулгамдаж байна. Нөгөөтэйгүүр Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэсний дагуу өргөдөл, гомдлоо шийдвэрлүүлэх иргэний үндсэн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, иргэдийн өргөдөл, гомдлыг судлах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, шаардлагатай бол бодлогын асуудлыг Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг нийтэд мэдээлэх Өргөдлийн байнгын хороотой байх нь зүйтэй гэж үзэв.

Эцэст нь, Улсын Их Хурлын гишүүдийн чуулганы хуралдааны ирц, санал хураалтад оролцож буй байдал, парламентад хэлэлцэж буй асуудлаарх улс төрийн зөвшилцлийг хангах, гишүүний ёс зүйн асуудалд онцгой анхаарч Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээлгэсэн онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлж, ард түмнийг төлөөлөн төрийн эрх барих үндсэн үүргээ нэр төртэй биелүүлэх бодит хэрэгцээ шаардлага үүссэн байгааг тоон үзүүлэлтүүд харуулж байна. Тухайлбал, 9 дэх удаагийн парламент бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлснээс хойш ирц хүрээгүйн улмаас Байнгын хороодын хуралдаан 38 удаа, ирц бүрдсэн ч зөвшилцөл хангаагүйн улмаас Байнгын хороодын хуралдаан 19 удаа нийт 57 удаагийн хуралдаан хойшилсон байна. Нөгөө талаас Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүйн асуудалтай холбогдуулан 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Ёс зүйн дэд хороонд 7 гомдол, 2026 оны I улиралд Ёс зүйн дэд хороонд 52 гомдол ирсэн байна. Энэ нь Улсын Их Хурлын гишүүдийн хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих, төлөөлөх Үндсэн хуулиар олгосон онцгой бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль зүйн механизм шаардлагатай болсон гэж дүгнэв.

Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалт, бүтээмж, бүрэн эрхээ хэрэгжүүлэх байдлын үр нөлөө, парламентын эргэх холбоотой, ил тод, хүртээмжийн түвшин нь төрд итгэх иргэдийн итгэл, парламентын нэр хүндэд шууд нөлөөлж байгаа тул дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачлан боловсруулна.

## **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байна. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

### **2.1.Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтыг оновчлох хүрээнд:**

✓ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Цахим хөгжил, хиймэл оюуны бодлогын, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн, Эрүүл мэнд, нийгмийн бодлогын байнгын хороог байгуулж нийт 11 Байнгын хороотой байхаар зохион байгуулж, түүнд нийцүүлэн Байнгын хороодын эрхлэх асуудлыг хуваарилна.

✓ Байнгын хороодыг сэргээн байгуулсантай холбоотойгоор, түүнчлэн практикт хэт олон дэд хороо байгуулж, улмаар дэд хороо холбогдох Байнгын хорооны эрхлэх асуудлыг ялгамжтай тогтоогоогүйгээс үүссэн асуудлыг шийдвэрлэж, Байнгын хороодын эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцуулахаар Тусгай хяналтын; Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал; Ёс зүйн; Төсвийн зарлагын хяналтын; Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын; Хүний эрхийн; Тогтвортой хөгжлийн зорилгын нийт 7 дэд хороодтой байхаар төсөл боловсруулж, дэд хороодын тоог наймаар цөөлнө.

✓ Байнгын хороог 11 болгосонтой холбогдуулан Байнгын хорооны бүрэлдэхүүнийг хуульд нийцүүлэн тогтоож, асуудал хариуцсан сайд нь холбогдох Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох өөрчлөлт хийнэ.

✓ Байнгын хорооны дарга нар хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад үед нэгдсэн хуралдаанд заавал оролцож Байнгын хорооны эрхлэх асуудалтай холбоотой асуултад хариулах үүрэгжүүлсэн зохицуулалт оруулна.

### **2.2.Улсын Их Хурлын гишүүдийн ирц, саналаа биечлэн өгөх хөшүүрэг бий болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд:**

✓ Ээлжит чуулганы хугацаанд гишүүний ирц, саналаа биечлэн өгсөн байдал, чуулганы хуралдаанд асуулт асуусан, үг хэлсэн тоо, дотоод, гадаад албан томилолт, хууль тогтоомжийн төсөл санаачилсан, хамтран санаачилсан, ажлын хэсэг ахалсан, бүрэлдэхүүнд нь ажилласан, хянан шалгах үйл ажиллагаанд оролцсон байдал болон хууль тогтоомжийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал, хариуцлага хүлээсэн эсэх талаарх мэдээллийг бодит цагийн горимоор олон нийтэд ил тод, тогтмол мэдээлэх;

✓ Гишүүн саналаа заавал биечлэн өгөхийг хуульчлах буюу гишүүн Улсын Их Хурлаар хэлэлцэж буй аливаа асуудлаар саналаа өгөхдөө заавал идэвхтэй үйлдлээр саналаа илэрхийлэх;

✓ Хууль тогтоомжийн төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлгийг шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооны хуралдааны явцад гишүүний горимын саналаар төслийн хэлэлцүүлгийг мэтгэлцээний горимд шилжүүлэх;

✓ Гишүүн хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ шударгаар хэрэгжүүлэхэд чиглэсэн гишүүний баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэмд тусгах бөгөөд хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих бодит оролцооны байдлыг үндэслэн гишүүнд Ёс зүйн дэд хороо ёс зүйн хариуцлага тооцдог, сонгогчдод мэдээлдэг байх үр нөлөө, бүтээмжид чиглэсэн хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх;

✓ Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын аль нэг дэд дарга хуулиар тогтоосон чиг үүргийнхээ хүрээнд Ёс зүйн дэд хороог удирддаг байх;

✓ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг болон гишүүний ёс зүйн дүрэм зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлагын төрөл, түүнийг хүлээлгэх нөхцөлийг тодорхой хуульчилна.

✓ Улсын Их Хурлаас батлан гаргаж буй хууль тогтоомжийн чанарыг сайжруулах хүрээнд Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд Тамгын газраас үзүүлж буй үнэлгээ, дүн шинжилгээг сайжруулах зохицуулалт хийнэ.

### ***2.3.Улсын Их Хурлын эргэх холбоо, хүртээмж, ил тод байдлыг сайжруулах, сонгогчдод мэдээллийг тогтмол хүргэх тогтолцоо бүрдүүлэх хүрээнд:***

✓ Гишүүдийн хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгаа мэдээллийг бодит цагийн горимоор иргэдэд тогтмол мэдээлэх байнгын тогтолцоо бүрдүүлэх;

✓ Улсын Их Хурлын даргыг сонгох хуралдааныг хэлэлцүүлэгтэйгээр явуулахаар өөрчлөх;

✓ Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь тусгай хэрэгцээт иргэдийн мэдээлэл авах, хуульд заасан тохиолдолд оролцох боломжийг хангахуйц хүртээмжтэй байх, Улсын Их Хурлын мэдээ, мэдээллийг нийтэд дамжуулахдаа дохионы хэл, товч бичгэн тайлбар зэргийг оруулж тусгай хэрэгцээт иргэдийн мэдээлэл авах, оролцох хүртээмжийг хангах;

✓ Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэн, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг судлан шийдвэрлэсэн байдал, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдвэрийнхээ талаарх мэдээллийг нэгтгэн сар бүр тогтмол мэдээлдэг байх тогтолцоо бүрдүүлэх;

✓ Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл улс орны нийгэм, эдийн засаг, эсхүл цаг үеийн шинжтэй хэлэлцэж байгаа хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын цахим хуудас, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, харилцаа холбооны хэрэгслээр иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах боломж бүрдүүлэх;

✓ Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн ач холбогдол, үр нөлөөг иргэдэд зориулан энгийн, ойлгомжтой, богино хэмжээний дүрс, бичгэн болон зурган зэрэг хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэх тогтмол иргэдийг мэдээллээр хангадаг байх;

✓ Өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл, хэлэлцүүлгийн явц болон баталсан хууль тогтоомжийн зохицуулалт, ач холбогдлыг хууль санаачлагч гишүүн, ажлын хэсэг, Байнгын хорооны дарга тайлбарлан таниулж, тогтмол мэдээлдэг байх нөхцөлийг бүрдүүлнэ.

✓ Нийтийн өргөдөлтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан зохицуулна.

#### ***2.4.Улсын Их Хурлын үйл ажиллагаанд оролцож буй байдлыг үндэслэн гишүүнд итгэл үзүүлэн дэмжих хууль зүйн механизм бүрдүүлэх хүрээнд:***

✓ Гишүүдийн хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх мэдээлэл буюу ирц, саналаа биечлэн өгсөн байдал, чуулганы хуралдаанд асуулт асуусан, үг хэлсэн тоо, дотоод, гадаад албан томилолт, хууль тогтоомжийн төсөл санаачилсан, хамтран санаачилсан, ажлын хэсэг ахалсан, бүрэлдэхүүнд нь ажилласан, хянан шалгах үйл ажиллагаанд оролцсон байдал болон хууль тогтоомжийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал, хариуцлага хүлээсэн байдал зэргийг үндэслэн, хүссэн Байнгын хорооны бүрэлдэхүүнд нь оруулах, Байнгын, дэд хорооны даргаар сонгох зэрэг үр нөлөөтэй ажиллаж байгаа гишүүнд итгэл үзүүлэн дэмжих хууль зүйн механизм бүрдүүлнэ.

#### ***2.5.Улсын Их Хурлын хэлэлцэж буй асуудлаар улс төрийн зөвшилцлийг хангах, парламентыг үл хүндэтгэх үйлдэлд хариуцлага тооцох бодит механизмыг иж бүрэн болгох хүрээнд:***

✓ Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах хүрээнд хэлэлцэж байгаа аливаа асуудлаар Улсын Их Хурал дахь улс төрийн зөвшилцлийг хангах арга хэмжээ авахыг Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн дарга нарт үүрэг болгох зохицуулалт оруулна.

✓ Хуралдаан даргалагч чуулганы хуралдааны явцад парламентыг үл хүндэтгэсэн үйлдэл гаргасан этгээдэд холбогдох хариуцлага хүлээлгэхээр томилох эрх бүхий этгээдэд албан бичиг илгээж, томилох эрх бүхий этгээд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх хариуг хуралдаан даргалагчид ирүүлэх бөгөөд ирүүлсэн мэдээллийг хуралдаан даргалагч хуралдаанд уншиж танилцуулах зохицуулалт хийнэ.

#### ***2.6.Хууль тогтоомжийн нийцлийг хангах, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хүрээнд:***

✓ 2024 онд шинэчлэн баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн үзэл баримтлалаас өөрөөр хэрэгжүүлж байсан зарим зохицуулалтын найруулгыг үзэл баримтлалд нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгахтай холбоотой өөрчлөлтийг боловсруулна.

✓ Тойргийн болон жагсаалтын гишүүдийн ажлын албаны орон тоог өөрөөр зохицуулсан байсныг тэгш байдлаар шийдвэрлэнэ.

✓ Тодорхой хугацаа хуулиар тогтоогоогүйн улмаас Улсын Их Хурлын үйл ажиллагааг гацаанд оруулж байсан асуудлыг хуулийн хугацаа тогтооно.

✓ Төсвийн хэлэлцүүлгийн үе шатыг өөрчилсөнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганыг 03 дугаар сарын 10-ны өдөр эхлүүлэхээр өөрчилнө.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар**

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд “Ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын гишүүний ирц, саналаа биечлэн өгсөн байдал, дотоод, гадаад албан томилолт, хуулийн төсөл санаачилсан, хамтран оролцсон, ажлын хэсэг ахалсан, бүрэлдэхүүнд нь ажилласан, хянан шалгах үйл ажиллагаанд оролцсон байдал болон төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал, хариуцлага хүлээсэн эсэх талаарх мэдээллийг бодит цагийн горимоор олон нийтэд тогтмол мэдээлэх”-ээр нэмж, Улсын Их Хурлын гишүүний Улсын Их Хурлын үйл ажиллагаанд оролцож байгаа тус объектив үзүүлэлтийг үндэслэн гишүүнд ёс зүйн хариуцлага оногдуулах, эсхүл Байнгын, дэд хорооны даргаар ажиллуулах итгэл хүлээлгэх тогтолцоо бүрдүүлснээр парламентын бүтээмж, үр нөлөөг дээшлүүлж, парламентад итгэх иргэдийн итгэлийг сайжруулна.

Хуулийн төсөл батлагдсанаар өнгөрсөн хугацаанд боловсролын салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, боловсролын хүртээмж, чанар, багш нарын хүртээмж, сургуулийн байрны хүртээмжийг сайжруулж, 3 ээлжээр хичээллэж буй тоо хэмжээг бууруулж, хүүхдүүдийн хүмүүжил, төлөвшил, боловсролын чанар сайжрах, Монгол Улсын цөлжилт, газрын доройтлыг шийдвэрлэх урт хугацааны бодлогын оновчтой шийдэл гаргах, Монгол Улсаас олон улсын өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх, байгалийн баялгаас хараат Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлж, олон тулгуурт болгох гарц болсон хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бүтээмжийг сайжруулах, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, түүнчлэн өгөгдөлд суурилсан мэдээлэл, дүн шинжилгээ хийж шийдвэр гаргахад үр өгөөжтэй ашиглах, цахим парламентыг хөгжүүлэх, кибер аюулгүй байдлыг хангах, шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмрийг дээшлүүлж, төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж, судалгааны үр дүн, оюуны өмч, шинэ технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломж болгох үр дүнтэй хөшүүрэг болно гэж үзлээ.

Ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын гишүүний ирц, саналаа биечлэн өгсөн байдал, гадаад, дотоод албан томилолт, хуулийн төсөл санаачилсан, хамтран оролцсон, ажлын хэсэг ахалсан, бүрэлдэхүүнд нь ажилласан, хянан шалгах үйл ажиллагаанд оролцсон байдал болон төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал, сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг бодит цагийн горимоор Улсын Их Хурлын албан ёсны мэдээлэл, харилцаа холбооны сувгуудаар тогтмол нийтэд ил тод мэдээлнэ.

Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь тусгай хэрэгцээт иргэдийн мэдээлэл авах, хуульд заасан тохиолдолд оролцох боломжийг хангахуйц хүртээмжтэй байна. Улсын Их Хурлын мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулахдаа дохионы хэл, товч бичгэн тайлбар (титр) зэргийг оруулж тусгай хэрэгцээт иргэдэд мэдээллийг бүрэн хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Улсын Их Хурлын хэлэлцэх асуудлын тов, дараалалд багтсан асуудал, Улсын Их Хурлаар батлагдсан хууль тогтоомж болон Улсын Их Хурлаар аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх явцын талаарх тогтмол мэдээлнэ. Тамгын газар Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн ач холбогдол, үр нөлөөг иргэдэд зориулан энгийн, ойлгомжтой, богино хэмжээний дүрс, бичгэн болон зурган хэлбэрээр бэлдэж Байнгын хорооны дарга, Ажлын хэсгийн ахлагч болон бүрэлдэхүүнд нь ажилласан гишүүн нийтэд мэдээлнэ.

Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэн, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг судлан шийдвэрлэсэн байдал, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдвэрийнхээ талаарх мэдээллийг багцлан ээлжит чуулганы хугацаанд нээлттэй мэдээлнэ.

Гишүүн бүр ээлжит чуулганы хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлангаа нийтэд тогтмол мэдээлнэ.

Түүнчлэн Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлэх хууль зүйн боломж нэмэгдэж, иргэдийн амьдралд тулгамдаад буй бодит асуудлыг шийдвэрлэх, төрд итгэх иргэдийн итгэл сэргэх, Улсын Их Хурлын Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээ оновчтой болж, Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалт сайжирна.

**Дөрөв. Хуулийн төслүүд нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг төслийг боловсруулан өргөн мэдүүлнэ.

---oOo---